



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/109/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhant@audit.gov.mn">batsaikhant@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Албан шаардлага .....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

**.Аудитын санал дүгнэлт**



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Г.НАРАНЖАРГАЛ  
ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012020848

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,186,246.12</b>	<b>235,845,621.26</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	10,064,055.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	10,064,055.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	10,064,055.45
31211	Төрийн сангийн харилцах	-	10,055,540.65
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	8,514.80
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	157,063,398.65
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	74,998.65
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	156,988,400.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,186,246.12	68,718,167.16
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,325,067.01	49,570,119.80
35130	Эм боох материал	7,325,067.01	49,570,119.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,861,179.11	19,148,047.36
35410	Бичиг хэргийн материал	80,500.00	77,500.00
35420	Аж ахуйн материал	8,165,889.11	15,499,346.36
35440	Түлш, шатах тослох материал	-	406,850.00
35450	Барилгын засварын материал	2,188,800.00	1,653,960.00
35460	Хүнсний материал	1,425,990.00	1,510,391.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>294,372,343.77</b>	<b>304,955,808.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	294,372,343.77	304,955,808.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	287,306,343.77	297,889,808.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	235,974,378.82	235,974,378.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,547,375.84)	(25,721,299.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,736,434.00	29,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,151,162.72)	(14,868,216.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,941,559.66	85,643,718.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(25,353,756.31)	(24,256,272.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,256,211.01	24,459,816.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,549,944.85)	(13,078,749.62)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,066,000.00	7,066,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,066,000.00	7,066,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>313,558,589.89</b>	<b>540,801,430.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,011,490.00</b>	<b>543,630.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,011,490.00	543,630.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,011,490.00	543,630.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	543,630.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>312,547,099.89</b>	<b>540,257,800.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	312,547,099.89	540,257,800.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	356,461,187.26	356,461,187.26
51101	Өмч: - төрийн	356,461,187.26	356,461,187.26
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(71,758,804.34)	155,951,895.80
51210	Өмнөх үеийн үр дүн	(71,758,804.34)	(71,758,804.34)
51220	Тайлант үеийн үр дүн	-	227,710,700.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,844,716.97	27,844,716.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>313,558,589.89</b>	<b>540,801,430.03</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>406,850,167.60</b>	<b>899,054,799.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,034,397.60</b>	<b>178,270,799.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	34,034,397.60	178,270,799.27
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,034,397.60	178,270,799.27
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,034,397.60	178,270,799.27
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>372,815,770.00</b>	<b>720,784,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	313,517,300.00	338,579,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	313,517,300.00	338,579,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,143,500.00	335,512,550.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,143,500.00	29,440,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,278,000.00
131110	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		301,794,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,400,600.00	24,996,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,400,600.00	24,996,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	24,754,370.00	21,695,550.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,754,370.00	21,695,550.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>417,933,875.34</b>	<b>670,709,919.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>417,933,875.34</b>	<b>670,709,919.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	415,843,022.84	633,924,897.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	239,377,247.00	274,619,134.52
210101	Үндсэн цалин	156,340,800.00	148,608,907.35
210102	Нэмэгдэл	61,504,494.00	92,199,741.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,054,988.00	4,294,999.91
210104	Урамшуулал	17,476,965.00	29,515,485.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,121,919.00	35,670,567.00
210201	Тэтгэврийн даатгал	22,422,231.00	24,819,121.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,285.00	2,776,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,986,647.00	2,204,541.00
210204	Ажилгүйдлийн даатгал	458,047.00	532,495.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,729,709.00	5,337,732.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,047,777.00	20,238,178.00
210301	Гэрэл, цахилгаан	3,750,052.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	7,030,425.00	18,552,178.00
210303	Цэвэр, бохир ус	267,300.00	91,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,959,147.14	21,642,648.22
210401	Бичиг хэрэг	1,399,490.00	1,200,350.00
210402	Тээвэр, шатахуун	9,575,250.14	13,046,781.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	906,440.00	544,200.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	80,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,171,500.00	1,537,140.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,336,010.00	5,234,176.82
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	45,558,059.16	229,530,846.03
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,140,865.66	219,085,048.73
210502	Хоол, хүнс	4,807,993.50	10,193,797.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,609,200.00	252,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,031,400.00	7,141,140.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	238,400.00	1,848,600.00
210604	Урсгал засвар	17,793,000.00	5,292,540.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	828,000.00	706,000.00

210702	Дотоод албан томилолт	828,000.00	706,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,532,622.00</b>	<b>2,252,160.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,337,636.00	250,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	209,200.00	209,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,206.00	56,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	255,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	70,660.00	70,660.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	349,920.00	1,392,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,386,851.54</b>	<b>42,124,224.04</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,685,900.00	5,950,023.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,700,951.54	36,174,201.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,090,852.50</b>	<b>36,785,022.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>36,784,000.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	1,829,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	29,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,280,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,339,328.00</b>	<b>1,022.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,339,328.00	1,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,083,707.74)</b>	<b>228,344,879.46</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>634,179.32</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	634,179.32
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(634,179.32)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,083,707.74)</b>	<b>227,710,700.14</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>372,815,770.00</b>	<b>563,795,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>372,815,770.00</b>	<b>563,795,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>313,517,300.00</b>	<b>338,579,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	313,517,300.00	338,579,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,143,500.00</b>	<b>178,524,150.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,143,500.00	29,440,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,278,000.00
131107	эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-	144,805,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>29,400,600.00</b>	<b>24,996,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,400,600.00	24,996,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>24,754,370.00</b>	<b>21,695,550.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,754,370.00	21,695,550.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>368,888,770.00</b>	<b>552,281,544.55</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>368,888,770.00</b>	<b>552,281,544.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>366,797,917.50</b>	<b>515,496,522.55</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>239,377,247.00</b>	<b>274,150,503.17</b>

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	156,340,800.00	148,683,906.00
210102	Нэмэгдэл	61,504,494.00	91,656,111.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,054,988.00	4,294,999.91
210104	Урамшуулал	17,476,965.00	29,515,485.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,121,919.00</b>	<b>35,670,567.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,422,231.00	24,819,121.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,525,285.00	2,776,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,986,647.00	2,204,541.00
210204	Ажилгүйдлийн даатгал	458,047.00	532,495.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,729,709.00	5,337,732.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,317,972.00</b>	<b>20,238,178.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,750,052.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	5,300,620.00	18,552,178.00
210303	Цэвэр, бохир ус	267,300.00	91,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,296,070.00</b>	<b>22,027,981.40</b>
210401	Бичиг хэрэг	1,224,290.00	1,197,350.00
210402	Тээвэр, шатахуун	8,597,750.00	12,468,631.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	906,440.00	544,200.00
210404	Ном, хэвлэл	75,000.00	80,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,282,800.00	1,907,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,209,790.00	5,830,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,807,387.50</b>	<b>149,193,409.98</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,877,000.00	138,151,961.68
210502	Хоол, хүнс	5,570,387.50	9,797,448.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,360,000.00	1,244,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,830,800.00</b>	<b>5,307,700.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,031,000.00	550,000.00
210604	Урсгал засвар	19,799,800.00	4,757,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>828,000.00</b>	<b>706,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	828,000.00	706,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,532,622.00</b>	<b>2,252,160.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,337,636.00	250,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	209,200.00	209,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,206.00	56,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	255,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	70,660.00	70,660.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	349,920.00	1,392,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,685,900.00</b>	<b>5,950,023.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,685,900.00	5,950,023.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,090,852.50</b>	<b>36,785,022.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>36,784,000.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	1,829,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	29,400,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,280,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,339,328.00</b>	<b>1,022.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,339,328.00	1,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,927,000.00</u></b>	<b><u>11,514,055.45</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,927,000.00</b>	<b>1,450,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,927,000.00</b>	<b>1,450,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,927,000.00</b>	<b>1,450,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,927,000.00	1,450,000.00

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(3,927,000.00)</u></b>	<b><u>(1,450,000.00)</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	10,064,055.45
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	10,064,055.45

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	-60,675,096.60	323,630,807.63
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>356,461,187.26</b>	<b>27,844,716.97</b>	<b>-60,675,096.60</b>	323,630,807.63
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,083,707.74	-11,083,707.74
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	<b>-71,758,804.34</b>	312,547,099.89
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	<b>-71,758,804.34</b>	312,547,099.89
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	<b>-71,758,804.34</b>	312,547,099.89
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	227,710,700.14	227,710,700.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,461,187.26	27,844,716.97	<b>155,951,895.80</b>	540,257,800.03

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	388,232,300.00	375,214,887.35
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	388,232,300.00	375,214,887.35
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	380,848,300.00	367,830,887.35
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	253,370,900.00	242,634,068.17
210101	Үндсэн цалин	154,543,100.00	148,683,906.00
210102	Нэмэгдэл	70,873,200.00	66,776,592.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,302,000.00	4,294,999.91
210104	Урамшуулал	23,652,600.00	22,878,569.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,765,200.00	31,593,602.00
210201	Тэтгэврийн даатгал	23,510,300.00	22,033,432.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,622,700.00	2,448,951.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,081,300.00	1,942,359.00
210204	Ажилгүйдлийн даатгал	503,200.00	468,734.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,047,700.00	4,700,126.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,239,200.00	20,238,178.00
210301	Гэрэл, цахилгаан	1,594,900.00	1,594,900.00
210302	Түлш, халаалт	18,553,200.00	18,552,178.00
210303	Цэвэр, бохир ус	91,100.00	91,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,830,600.00	18,822,881.40
210401	Бичиг хэрэг	790,700.00	790,650.00
210402	Тээвэр, шатахуун	12,436,800.00	12,436,781.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	544,200.00	544,200.00

210404	Ном, хэвлэл	80,000.00	80,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	807,500.00	807,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,171,400.00	4,163,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38,877,200.00</b>	<b>38,876,274.78</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,519,300.00	32,519,107.48
210502	Хоол, хүнс	5,113,900.00	5,113,167.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,244,000.00	1,244,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,757,700.00</b>	<b>6,757,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,450,000.00	1,450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550,000.00	550,000.00
210604	Урсгал засвар	4,757,700.00	4,757,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>776,000.00</b>	<b>706,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	776,000.00	706,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,281,400.00</b>	<b>2,252,160.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	280,000.00	250,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	209,200.00	209,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,500.00	56,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	70,700.00	70,660.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,392,000.00	1,392,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,950,100.00</b>	<b>5,950,023.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,950,100.00	5,950,023.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,384,000.00</b>	<b>7,384,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,384,000.00</b>	<b>7,384,000.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,829,000.00	1,829,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,275,000.00	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,280,000.00	1,280,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>24,996,900.00</b>	<b>24,995,878.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,996,900.00</b>	<b>24,995,878.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	24,996,900.00	24,995,878.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>10,055,540.65</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр / Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>178,515,635.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>178,515,635.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>149,115,635.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>31,516,435.00</b>
210102	Нэмэгдэл	24,879,519.00
210104	Урамшуулал	6,636,916.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>4,076,965.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,785,689.00
210202	Тэтгэмжийн даатгал	327,727.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	262,182.00
210204	Ажилгүйдлийн даатгал	63,761.00
210205	Эрүүл мэндийн даатгал	637,606.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,205,100.00</b>
210401	Бичиг хэрэг	406,700.00
210402	Тээвэр, шатахуун	31,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,666,550.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>110,317,135.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,632,854.20

210502	Хоол, хүнс	4,684,281.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29,400,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	178,524,150.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	178,524,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,440,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,278,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	144,805,600.00
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	8,514.80

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай үзүүлсэн эрүүл мэндийн боловсрол олгоход оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолтын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 670,187.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,701.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,694.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар буюу 6,701.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланд залруулга хийгдэж нийт зардал өөрчлөгдсөн тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар буюу 6,707.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 10,992.2 мянган төгрөгөөр тооцон шинэчлэн тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 227,242.8 мянган төгрөгөөр буюу 72 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10,064.0	10,064.0
Авлага	-	157,063.4	157,063.4
Бараа материал	19,186.2	68,718.2	49,532.0
Үндсэн хөрөнгө	294,372.4	304,955.8	10,583.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>313,558.6</b>	<b>540,801.4</b>	227,242.8
<b>Өр төлбөр</b>	<b>1,011.5</b>	<b>543.6</b>	(467.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	312,547.1	540,257.8	227,710.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>313,558.6</b>	<b>540,801.4</b>	227,242.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд нэмэлт санхүүжилт дансны 8.5 мянган төгрөг, төсвийн харилцах дансны 10,055.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тус тус байна.

Авлага данс өмнөх оноос 157,063.4 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалаас авах хэвтэн эмчлүүлэгчдийн үйлчилгээний орлогын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 68,718.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 49,532.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 138,011.5 мянган төгрөг, хандив тусламжаар 124,189.6 мянган төгрөгийн эм боох материал хүлээн авсантай холбоотой байна.

Эм боох материалын дансны эцсийн үлдэгдэл 49,570.1 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ковид-19 цар өвчин гарсантай холбоотойгоор вакцинжуулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,450.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 45,941.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 26,871.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 540,801.4 мянган төгрөг болж 227,242.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388,232.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 388,232.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээрх дүнгээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 388,232.3 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 375,214.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2,960.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан нь үндсэн үйл ажиллагааны 4 тусламж үйлчилгээг ковидын нөхцөл байдлаас шалтгаалж дутуу үзүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 375,214.9 мянган төгрөг буюу 96.3 хувийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, 10,055.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 29,440.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,278.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 144,805.6 мянган төгрөг нийт 178,524.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 3,205.1 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 31,516.4 мянган төгрөг, нормативт зардалд 110,317.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 29,400.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 4,076.9 мянган төгрөг нийт 178,515.6 мянган төгрөгийг зарцуулж 8.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 262,201.1 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин худалдан авч, 219,956.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 80 ширхэг эмийн үнийн зөрүү 1,028.1 мянган төгрөгийн, эм боох материалын 531.5 мянган төгрөгийн орлогыг бараа материалын, 3,508.6 мянган төгрөгийн орлогыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй алдааг тус тус аудитын явцад залруулсан.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Луус сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 338,232.3 мянган төгрөгийн 147 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг зөрчсөн зөрчлүүдийг арилгах албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар батлагдаагүй орон тоонд эм баригч ажиллуулан ажил хавсарсны нэмэгдэл 3,839.0 мянган төгрөгийн цалин бодож олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,127.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,127.1 төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хяналтын тооллогоор 47.3 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан .
2. Хяналтын тооллогоор 11.6 мянган төгрөгийн хүнсний материалын илүүдэл гарсан.
3. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 1,028.1 мянган төгрөгөөр зөрүүтэй дүнгээр нэхэмжилсэн.
4. Эм боох материалын 531.5 мянган төгрөгийн орлогыг бараа материалын дансанд бүртгээгүй.
5. Машин , тоног төхөөрөмжийн 3,508.6 мянган төгрөгийн орлогыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй

*Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитын явцад 58.9 мянган төгрөгийн залруулга хийж, аудитын явцад 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 5,068.2 мянган төгрөгийн нийт 5,127.1 мянган төгрөгийн залруулга хийсэн.*

### 4.2 Албан шаардлага

1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж урамшуулал авсан.

*Шийдвэрлэсэн нь: 2021 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

### 4.4 Зөвлөмж

#### 1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Завсрын аудитаар эд хариуцагчийн хариуцлагын гэрээ хийж дүгнээгүй.

*Өгсөн зөвлөмж: Ажилтантай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж, түүний үр дүнг тооцож ажиллах.*

- 1.2 Илрүүлэлт: Хяналтын тооллогоор ашиглагдахгүй хөрөнгө ихтэй, акталж устгалд оруулаагүй.

*Өгсөн зөвлөмж: Ашиглагдахгүй байгаа хөрөнгийн жагсаалтыг гаргаж сумын Өмч хамгаалах зөвлөлд хүргүүлж шийдвэр гаргуулах.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>												
1	Эд хариуцагчийн хариуцлагын гэрээг хийж, дүгнээгүй										1	
2	Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргаж урамшуулал авсан.							1				
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>												
1	Хяналтын тооллогоор хүнсний материал дутагдсан.			1	47.3							
2	Хяналтын тооллогоор хүнсний материалын илүүдэл гарсан.			1	11.6							
3	Хяналтын тооллогоор ашиглагдахгүй хөрөнгө ихтэй, актлаж, устгалд оруулаагүй										1	
4	Эм нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилснийг бараа материалын тайланд илүү тайлагнасан			1	1,028.1							
5	Эм боох материалын орлогыг бараа материалын дансанд бүртгээгүй.			1	531.4							
6	Машин, тоног төхөөрөмжийн орлогыг үндсэн дансанд бүртгээгүй			1	3,508.6							
	Нийт зөрчлийн дүн	8	5,127.1	5	5,127.1			1			2	